



БАЙГАЛЬ ОРЧИН
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ



“ЗУУННАЙМАН ОЙЛ” ХХК-ИЙН ХАРЪЯА ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ “НЕФТЬ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ГААЛИЙН БАТАЛГААТ АГУУЛАХ”-ЫН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН



БОЛОВСРУУЛСАН: “ЗУУННАЙМАН ОЙЛ” ХХК-Н ХАБЭА-Н АЖИЛТАН *Б. Маралмаа* Б. МАРАЛМАА

ЧОЙР ХОТ

2023 ОН

Агуулга

1. Төслийн товч танилцуулга
2. Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл
3. Байгаль орчны менежментийн тухайн жилийн төлөвлөгөөний гол зорилт
- 3.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт
- 3.2. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөгий биелэлт
- 3.3. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт
- 3.4. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт
- 3.5. Химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт
- 3.6. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт
- 3.7. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт
- 3.8. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр
- 3.9. БОМТ, түүний хэрэгжилтийг оролцогч сонирхогч талуудад тайлагнах хэлэлцүүлэх хуваарь
- 3.10 Дүгнэлт

ГААЛИЙН ХЯНАЛТЫН БҮСИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

“Зууннайман Ойл” ХХК нь анх 2008 онд улсын бүртгэлийн гэрчилгээг 2010 оны 9-р сарын 28ны өдрөөс үйл ажиллагаагаа албан ёсоор эхэлсэн. ГХБ нь Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын 1-р багийн нутаг дэвсгэрт байрлалтай, Гаалийн ерөнхий газрын даргын 2019 оны А/294 дүгээр тушаал хавсралтаар батлагдсан “Гаалийн хяналтын бүсийн журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.2 дахь хэсэг, мэргэжлийн зөвлөлийн хуралдааны 2020 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн 4/04 дугаартай шийдвэрийг тус тус үндэслэн өөрийн эзэмшлийн газар нутаг болох 36000м.кв бүхий талбай дээр ГХБ-н 76000 т.кв талбайг 2020 оны 10 дугаар сарын 15-нд 3 жилийн хугацаатай ашиглалтанд орсон болно.

Тус ГХБ-н зураг төсөл бөгөөд барилга угсралтын ажил болон цахилгааны 413 кВа-гийн дэд өртөөг “ОРХОН ДИЗАЙН” ХХК хийж гүйцэтгэсэн.

ТӨСЛИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

“Зууннайман Ойл” ХХК нь 2017 оны 8-р сарын 29-нд “Ви Эс Ойл ” ХХК-ний мэдэлд шилжин бүх төрлийн шатахууны импортын үйл ажиллагаа шатахууны бөөний худалдаа эрхлэх аж ахуйн тусгай зөвшөөрлийг 2017 оны 10 сарын 17-ны өдөр УУХҮЯамнаас авсан байна. Үүнтэй уялдуулан олон улсын чанартай бараа, бүтээгдэхүүнийг хадгалах, тээвэрлэх, дамжин өнгөрүүлэх Гаалийн баталгаат агуулах болгон өргөжүүлэхээр “Хосмустанг ХХК” -тай хамтран 26,5 га газар дээр 2017 оны 12-р сард Говьсүмбэр аймгийн ИНХ-ын тогтоолын дагуу 20 га газрыг нэмж эзэмших тогтоол гарсанаар 48,5 га талбайг “Нефтийн бүтээгдэхүүний гаалийн баталгаат агуулах” төсөл хэрэгжсэн юм.

Төсөл хэрэгжүүлэгч нь 2018 он гарсаар төсөл хэрэгжих талбайд гүний худаг гаргуулан, ус ашиглах зөвшөөрөл авч дүгнэлт гаргуулснаас гадна 3,2 км төмөр замыг шинээр ашиглалтанд оруулсныг улсын онцгой комисс 2018 оны 2-р сарын 7-нд ашиглалтад хүлээн авсан болно.

Төслийн нэр

“Нефть бүтээгдэхүүний гаалийн баталгаат агуулах” төсөл

Төслийн дугаар


2017/АЗ-133

Төсөл хэрэгжүүлэгч

“Зууннайман ойл” ХХК Улсын бүртгэлийн дугаар 9011316010, Регистрийн дугаар 5272378

Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Чингисийн Өргөн чөлөө, Ланд Марк Оффис, 601 тоот

Утас: 976-77001042



НҮҮР ТАЛ / тэнхлэг А-В /



Төслийн зорилго

Гаалийн баталгаат агуулах нь төрөл бүрийн ачааг хүлээн авах, олгох, хадгалах, барилгын материалыг түр хугацаагаар хадгалах зэргээр өргөж буулгах автоматжуулсан механизм бүхий тоног төхөөрөмжөөр тоноглох юм.

Гаалийн баталгаат агуулахад:

- ❖ Импортоор орж, ирж байгаа ачаа,
- ❖ Экспортод гарч байгаа ачаа,
- ❖ Дамжин өнгөрөх транзит ачааг гаалийн хяналтанд байлгах зориулалттай агуулахын байгууламжууд байх болно.

Төслийн байршил

Төсөл хэрэгжиж буй газар нь Улаанбаатар хотоос 220 км, Говьсүмбэр аймгийн зүүн хойд талд ойролцоогоор 6 км-ийн зайд нийт 48.5 га талбайг эзлэн байрлана.

Төслийн баруун талд нь Монгол улсын хойд хил Алтанбулаг боомтоос урд хил Замын Үүдийг холбосон гол төмөр зам, зүүн талд нь Алтанбулаг–Улаанбаатар – Замын Үүд чиглэлийн улсын болон олон улсын чанартай АНЗ автозам оршино

Газар зүйн солбицол:

- | | |
|--|--|
| 1. 46 ⁰ 22 ^I 35.11 ^{II} | 108 ⁰ 20 ^I 54.67 ^{II} |
| 2. 46 ⁰ 22 ^I 37.72 ^{II} | 108 ⁰ 20 ^I 51.88 ^{II} |
| 3. 46 ⁰ 22 ^I 45.98 ^{II} | 108 ⁰ 20 ^I 56.23 ^{II} |
| 4. 46 ⁰ 22 ^I 40.24 ^{II} | 108 ⁰ 21 ^I 03.43 ^I |



3. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ

Байгаль орчны менежментийн тухайн жилийн төлөвлөгөөний гол зорилт

“Зууннайман ойл” ХХК-ийн ГХБ-ийн агуулахын байгаль орчны менежментийн төлөвлөгөөний агуулга бүтцийн хувьд тухайн жилийн байгаль орчны менежментийн төслийн явцад технологи үйл ажиллагааны улмаас үүсч болзошгүй сөрөг нөлөөллүүдийг байгаль орчны бүрэлдэхүүн тус бүрээр авч үзэх үүнд агаар, хөрс, ургамал, амьтан, болон төслийн талбайн ойролцоох нутгийн иргэд гэх мэт.

Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх.

Эрсдлийн үнэлгээ, хог хаягдлын менежмент, нөхөн сэргээлт, байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулж, байгаль орчны тухайн жилийн менежментийн тайланд тусгах.

Тухайн жилийн байгаль орчны менежментийн гол зорилго нь байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээний дүгнэлтэд заасан чиглэл, хуваарийн тухайн төслийн үйл ажиллагаанаас байгаль орчин, эдийн засагт үзүүлэх эерэг болон сөрөг нөлөөллийг тодорхойлох, хүний эрүүл мэнд байгаль орчин, эдийн засгийн үр ашигт учруулах эрсдлийг тодорхойлох, сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг тодорхойлоход оршино.

1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний зорилт

Төслийн хэрэгжилтээс байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг байгалийн хам бүрдэл тус бүрийн хувьд дэлгэрүүлэн авч үзэхэд дараах байдалтай байна.

Үүнд :

- ❖ Усан орчинд үзүүлэх нөлөөлөл
- ❖ Хөрсөн бүрхэвч болон газрын хэвлийд үзүүлэх нөлөөлөл
- ❖ Агаар орчинд үзүүлэх нөлөөлөл
- ❖ Ургамлан нөмрөгт үзүүлэх нөлөөлөл
- ❖ Ажиллагсдын эрүүл мэндэд үзүүлэх нөлөөлөл

Төслөөс үүсэх гол сөрөг нөлөөллийг бууруулахын тулд тайланд тусгагдсан зөвлөмжүүдийг хэрэгжүүлэн ажиллах шаардлагатай. Гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх анхааруулах, таниулах, сурталчлах арга хэмжээг зохион байгуулах галын сарайны гал унтраах анхан шатны багаж хэрэгсэл галын хорны иж бүрдлийг бүрдүүлэх бэлэн байдлыг хангаж ажиллахад оршино.

2. Осол эрсдэлийн менежментийн гол зорилт

- ❖ Болзошгүй аюул осол, техник технологи, шугам сүлжээний гэмтэл, галын гэнэтийн аюул осол үүсэхээс урьдчилан сэргийлэх

3. Нүүлгэн шилжүүлэх нөхөн олговор олгох арга хэмжээний зорилт

- ❖ “Зууннайман ойл” ХХК төслийн үйл ажиллагаагаар газар чөлөөлөх, нүүлгэн шилжүүлэх ажил явагдахгүй.

4. Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний зорилт

- ❖ “Зууннайман ойл” ХХК-ийн ГХБ талбайн ойролцоо түүх соёлын дурсгалт зүйлс байхгүй бөгөөд төслийн үйл ажиллагааны үед түүх соёлын дурсгалт зүйлсийг хөндөх, түүнд сөрөг нөлөөлөл үзүүлэхгүй тул БОМТ-нд соёлыг хамгаалах арга хэмжээ тусгагдаагүй болно. Харин төслийн үйл ажиллагааны үед түүх соёлын дурсгалт зүйл, булш, бунхан хиргисүүр, археологи, палеонтологийн зүйлс илрэх тохиолдолд соёлын

өвийг хамгаалах үүднээс үйл ажиллагааг зогсоож, хууль ёсны дагуу мэргэжлийн байгууллагад хандаж мэдэгдэл хүргүүлнэ.

5. Химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөөг тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд төлөвлөж тусгаагүй болно.

6. Хог хаягдлын менежментийн зорилт

- ❖ Энгийн хог хаягдлаа ангилан ялгах, хог хаягдлын цэгийг стандарт шаардлагын дагуу байгуулах, шаардлага хангасан ангилан ялгах хогийн сав байршуулах
- ❖ Хог хаягдал цуглуулах, тээвэрлэх эрх бүхий аж ахуйн нэгж, байгууллагатай хог тээврийн үйлчилгээний гэрээ байгуулах, үүссэн хог хаягдлаа тогтмол зайлуулах
- ❖ Үүсэх хог хаягдлыг ангилан ялгах, хог хаягдал цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, шатаах, устгахдаа үйл ажиллагаатай холбоотой гэрээ байгуулах, гэрээний хэрэгжилтэд хяналт тавих
- ❖ Байгууллагын дотоод болон гадна орчны цэвэрлэгээг хариуцах үүрэг бүхий нэгж

7. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын гол зорилт

- ❖ Нийт ажилчдыг эрүүл аюулгүй ажиллаж, амьдрах нөхцлөөр хангах, галын болон байгалийн гамшиг гэнэтийн аюул ослын үед бэлэн байх түргэн шуурхай арга хэмжээ авах нөхцлийн бүрдүүлэх, ажилчидыг сургалтанд хамруулах

8. Орчны хяналт шинжилгээний арга хэмжээний зорилт

- ❖ Агаарын бохирдлын шинжилгээ хийлгэх
- ❖ Усны хяналт шинжилгээ хийлгэх
- ❖ Хөрсний хяналт шинжилгээг хийлгэх

9. БОМТ, түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх хуваарь

- ❖ Иргэд олон/нийт дурын оролцогч, сонирхогч талууд, санал хүсэлт хүлээн авч төсөлтэй холбогдох гомдлыг барагдуулах
- ❖ Байгаль орчны хяналтын улсын байцаагч/ Орон нутгийн байцаагч/-д жилийн тайланг хүргүүлж танилцуулга хийх ба санал авах
- ❖ Сүмбэр сумын засаг даргад жилийн тайланг хүргүүлж танилцуулга хийх ба санал авах
- ❖ Багийн ИНХ-д жилийн тайланг хүргүүлж танилцуулга хийх ба санал авах

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлт

3.1 Сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөөний биелэлт

№	Сөрөг нөлөөллийг арилгах бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөсөн ажил	Хийгдсэн ажил	Нийт зардал, төг
Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ				
1.	“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнд нэгдэх	Талбайд үүсэх тоос шороог багасгах	Төслийн талбайд нийт 1000 гаруй мод тарив.	10.000.0
2.	ГСА-н БОАЖГ-тай хамтран мод бут тарих тухай заавар зөвлөмж аван нийт ажилтанууддаа мэдлэг олгуулах	БОАЖГ-тай хамтран мод бут хэрхэн зөв тарих, усалгаа арчилгааны талаар сургалт авах	ГСА-н Ойн ангийн мэргэжилтэн Э. Мөнх-Өлзийгөөс мод, бут хэрхэн тарих зөвлөгөө авсан.	100.000
3.	Хог хаягдалын тухай хуулиар иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг стандартын бус нүхэн жорлон хөрсийг бохирдуулж байдаг.	Хуучин нүхэн жорлонг стандартын дагуу булан эзэмшлийн газартаа нүхэн жорлонг байгуулах		1.000.000
4.	Аюултай хог хаягдлууд нь хөрс болон агаарыг бохирдуулж байдаг.	Аюултай хог хаягдлуудыг түр хадгалан хог хаягдал цуглуулах, тээвэрлэх эрх бүхий мэргэжлийн байгууллагад шилжүүлэн бүртгэл хөтлөх	Техникүүдээс сольсон хуучин тос маслуудыг дахин ашиглах засварын газруудад өгөв.	100.000
5.	Эзэмшлийн бус газарт жонш болон жоншны шороог буулган хөрсний бохирдол үүсгэх аюултай.	Талбайн хашаан гадна байгаа жонш, жоншны шороог Сүмбэр сумтай тохиролцон газар заалгаж тээвэрлэн зайлуулах	Талбайн хашаан гадна байгаа жонш, жоншны шороог машинд ачуулан Баяжуулах үйлдвэрт өглөө.	800.000
6.	Талбайд байгаа битумд асгаралт үүсэн хөрсийг бохирдуулж байна.	Асгарсан битум болон битумын үлдэгдэлүүдийг савлан асгаралтгүй болгон хөрсийг хамгаалах	Талбайн хөрсөнд асгарсан битумуудыг дахин хайрцаг хийн савлав.	500.000
	Нийт		12.500.000	

3.1.1 Тэрбум мод аяны хүрээнд 1010 ширхэг хайлаас, улиас, шар хуайс тарин услагаа арчилгааг тогтмол хийж байна.

Мод тарихын тулд төслийн талбайн хойд талбайг болон оффисыг тойруулан мал, амьтан мод идэхээс сэргийлэн хашаалав. Нийт 150 ширхэг шон 2000 метр өргөстэй тороор хашаа хийв.



-2023 оны 6-р сард 237 ширхэг улиас болон шар хуайсыг Улаанбаатар хотоос авчран тарив.



-Услугаа хийхэд шаардлагатай услугааны шланг 4 боодол, эргэдэг услугааны төхөөрөмж 2 ширхэг, услугааны буу 1ш, мод ухагч цахилгаан 1ш, механик мод ухагч 1ш зухгүүдийг худалдан авсан.



-2023 оны намар 300 ширхэг улиасыг Улаанбаатар хотоос авчран тарив.



-2023 оны 10-р сарын 5 нд ГСА-ийн Ойн ангиас 400 ширхэг улиас, 100 ширхэг хайлаас худалдан авч тарив.



-Модны нүхээ ухаж байх явцдаа моднуудаа бордоотой усанд хийн хадгалж байв. Мөн моднуудаа тарьсанаас 14 хоногийн дараа бордоо хийн услага, арчилгааг тогтмол хийв.



-Нийт 1000 гаруй мод тарихдаа бууц, элстэй холин хийхээр бууц татав.



-2023 онд 1000 гаруй мод тарьсан ба нийт 9.700.880 төгрөгний төсөв зарцуулсан байна.

3.1.2 Мод, бут тарих тухай Говьсүмбэр аймгийн Ойн ангийн мэргэжилтэн Э. Мөнх-Өлзийгөөс зөвлөгөө аван зөвлөмжийн дагуу моднуудаа тарьялаа.



3.1.3 Аюултай хог хаягдал буюу техникүүдийн сольсон тос, маслуудыг цуглуулан зориулалтын саванд хадгалдаг ба дахин ашиглахаар засварын газарт өгөв.




3.1.4 Төслийн талбайн хашааны урд талд байгаа жоншны хаягдал, шороог 15 машинд ачуулан Баяжуулах үйлдвэрт өгөв.



3.1.5 Талбайд байгаа асгарсан битумуудыг дахин савлахаар шинээр хайрцаг хийн савлуулав. Нийт 50 хайрцаг хийн савлуулсан.



3.1.6 Нүхэн жорлонг анх барихад стандартын дагуу барьсан ба Зууннайман Ойл ХХК-ий эзэмшлийн талбай дээр байдаг болно.




-Сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөөний биелэлтэд 2023 онд нийт 12.428.880 төгрөгийг зарцуулсан байна.

3.2 Осол эрсдэлийг арилгах бууруулах арга хэмжээний биелэлтийн тайлан

Осол эрсдэлийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө			
№	Осол эрсдэлийг бууруулах арга хэмжээ	Хийгдсэн ажил	Нийт зардал, төг
1.	Ажилчдын хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны дүрмийг мөрдөж байгаа эсэхэд хяналт тавих	ХАБЭА-н зааварчилгааг тогтмол өгч, ажилчдыг хэрхэн мөрдөж байгаа эсэхэд хяналт тавьсан.	50.000
2.	Ажилчдыг хор саармагжуулах бүтээгдэхүүнээр сар бүр тогтмол хангах	Нийт ажилчдад улирал бүр өдөр тутам хор саармагжуулах бүтээгдэхүүнээр тогтмол хангадаг.	300.000
3.	Галын аюулаас урьдчилан сэргийлэх талаар сургалт зохион байгуулах	Галын хорыг хэрхэн ашиглах анхан шатны сургалтыг ажилчиддаа хийсэн.	100.000
4.	Ачаа барааг өргөх, зөөх тээвэрлэхдээ унагах, эвдрэл гэмтэлээс сэргийлэн аюулгүй байдлыг хангах	Ачаа барааг өргөх тээвэрлэх үед анхаарч байх санамж, тэмдэг тэмдэглэгээг байрлуулан ажилчдад зааварчилгааг тогтмол өгөн эвдрэл гэмтлээс сэргийлдэг.	100.000
5.	Галын аюулаас урьдчилан анхааруулсан санамж тэмдэг тэмдэглэгээний тоог нэмэгдүүлэх, гал унтраах багаж хэрэгслийн иж бүрдлийг бүрэн хангах, бэлэн байлгах	Галын аюулаас урьдчилан анхааруулсан санамж тэмдэг, тэмдэглэгээний тоог нэмэгдүүлсэн. Мөн гал унтраах багаж хэрэгслийн иж бүрдлийн тоог нэмэгдүүлэн, бэлэн болгосон.	300.000
6.	Техникүүдэд урсгал үасварыг хийлгэж, эвдрэл гэмтлийг хурдан арилгуулж осол эрсдэл гарахаас урьдчилан сэргийлэх	Техникүүдийн мот цагийн үйлчилгээ болон өвөл, зуны урсгал засваруудыг тогтмол хийлгэх	400.000
ДҮН		1.250.000	

3.2.1 Урьдчилсан болон анхан шатны зааварчилгаа, өдөр тутмын зааварчилгааг тогтмол өгдөг.



3.2.2 Нийт ажилчидыг хор саармагжуулах бүтээгдэхүүнээр улирал тутам тогтмол хангадаг. Сард 23 хайрцаг найруулдаг аарц авдаг. 1 хайрцаг аарц 12000 төгрөг болно. Хор саармагжуулах бүтээгдэхүүнд жилд 3.456.000 төгрөг зарцуулэ байна.



3.2.3 Чойр өртөө болон Онцгой байдлын газраас хамтран зохион байгуулсан галын аюулаас урьдчилан сэргийлэх сургалтанд нийт ажилтануудыг хамруулсан.



3.2.4 Ачаа барааг өргөх, зөөх тээвэрлэх үеийн аюулгүй ажиллагааны сургалтыг ХММ-н операторууд болон оосорлогч нарт хийв.



3.2.5 Тэмдэг тэмдэглэгээнүүд болон гал унтраах анхан шатны хэрэгслүүд болох галын сарайнуудыг засаж янзлав. Хүрзний иш хугарсан байсныг солин галын сарайнуудыг хэрэгслүүдийг будаг өнгийг сэргээв. Мөн даралтгүй болсон 6 галын хорнуудыг хураан, хэвийн ашиглалттай галын хорыг галын сарайнд байршууллаа. Мөн галын сарайны будгийн өнгийг сэргээв.



3.2.6 Техникүүдэд урсгал засварыг хийлгэж, эвдрэл гэмтлийг хурдан арилгуулж осол эрсдэл гарахаас урьдчилан сэргийлдэг.



-Осол эрсдэлийг арилгах бууруулах арга хэмжээний биелэлтэнд 2023 онд нийт 4.406.00 төгрөг зарцуулсан байна.

3.3 Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний тайлан

“Зууннайман ойл” ХХК төслийн үйл ажиллагаагаар газар чөлөөлөх, нүүлгэн шилжүүлэх ажил явагдахгүй.

3.4 Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний тайлан

“Зууннайман ойл” ХХК-ийн ГХБ талбайн ойролцоо түүх соёлын дурсгалт зүйлс байхгүй бөгөөд төслийн үйл ажиллагааны үед түүх соёлын дурсгалт зүйлсийг хөндөх, түүнд сөрөг нөлөөлөл үзүүлэхгүй тул БОМТ-нд соёлыг хамгаалах арга хэмжээ тусгагдаагүй болно. Харин төслийн үйл ажиллагааны үед түүх соёлын дурсгалт зүйл, булш, бунхан хиргисүүр, археологи, палеонтологийн зүйлс илрэх тохиолдолд соёлын өвийг хамгаалах үүднээс үйл ажиллагааг зогсоож, хууль ёсны дагуу мэргэжлийн байгууллагад хандаж мэдэгдэл хүргүүлнэ.

3.5 Химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөөг тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд төлөвлөж тусгаагүй болно.


3.6 Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

№	Хог хаягдалын менежментийн төлөвлөсөн арга хэмжээ	Хийгдсэн ажил	Нийт зардал, төг
1	Хатуу хог хаягдал, арчих материалыг зориулалтын битүү саванд ангилан хуримтлуулж хогийн цэгт хаях	Хогийн цэгт тогтмол ариутгал хийж байгаа.	100.000
2	Хог хаягдлыг ангилан зайлуулах дахин ашиглах боломжтой хог хаягдлыг дахин боловсруулах зөв менежментийг хэрэгжүүлэх	Нийт ажилчиддаа хогнуудаа ангилан хаях тухай анхан шатны сургалтыг хийсэн.	
3	Бие засах газар, бохир ус хадгалах байгууламжийг стандартын дагуу ариутгал халдваргүйжүүлэлтийг тогтмол хийлгэх	7 хоног тутамд 1 удаа ариутгал халдваргүйжүүлэлтийг хийлгэдэг.	300.000
4	“Тохижилт Сүмбэр” ОНӨААТҮГ-тай хамтран гэрээ байгуулж хог хаягдалаа төвлөрсөн хогийн цэгт хаях.	“Тохижилт Сүмбэр” ОНӨААТҮГ-тай хамтран гэрээ байгуулсан, хогоо сар тутам ачуулдаг.	600.000
Дүн		1.000.000	

3.6.1 Шатах тослох материалыг арчих материалыг хийх зориулалтын битүү саванд ангилан хуримтлуулан хадгалж байна. Гидрийн шингэний төмөр савыг ашиглан арчих материалын хогийн савыг хийн энэхүү хогийн савандаа шатах тослох материал арчсан материалуудаа хадгалдаг болно.



3.6.2 Хог хаягдалыг ангилан ялгаж дахин боловсруулагдах хуванцар савуудыг цуглуулсан ба Дахивар хог авах өдөрлөгөөр. Мөн дахин боловсруулах хог хаягдалын бүртгэлийг хөтлөдөг.



3.6.3 “Тохижилт Сүмбэр” ОНӨААТҮГ-тай хамтран гэрээ байгуулж хог хаягдалаа ачуулан төвлөрсөн хогийн цэгт хаядаг. Гэрээний дагуу сард 1 удаа хогоо ачуулдаг.



3.6.4 Хогийн цэг болон бие засах газрыг жавелины уусмалаар 14 хоногт 1 удаа ариутгадаг.



-Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлтэд 2023 онд нийт 800.00 төгрөг зарцуулсан байна.

3.7 Тухайн жилийн менежментийн төлөвлөгөөний удирдлага зохион байгуулалт

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Хийгдсэн ажил	Нийт зардал
Тухайн жилийн менежментийн төлөвлөгөөний удирдлага зохион байгуулалт			
1	Говьсүмбэр аймгийн ОБГ-тай хамтран гал түймэр утнраах болон аврах тактикийн сургуулилт зохион байгуулах	Галын болон байгалийн гамшиг гэнэтийн аюул ослын үед бэлэн байх түргэн шуурхай арга хэмжээ авах нөхцлийг бүрдүүлэх	100.000
2	Үйл ажиллагаа явуулахтай холбогдуулан төрийн байгууллагын хяналт шалгалт, орон нутгийн Засаг захиргаанаас тавьж буй шаардлага зөвлөмжийг биелүүлж хамтран ажиллах.	Төрийн хяналт шалгалт албан шаардлага, заавар зөвлөмжийг дагаж мөрдөх биелүүлдэг.	-
3	Нийт ажилчдад Байгаль орчны тухай хууль, мод бут тарих сургалтыг зохион байгуулах	Нийт ажилтануудыг сургалтанд хамруулж анхан шатны мэдлэг олгох	100.000
4	Удирдах албан тушаалтануудыг ХАБЭА-н сургалтанд суулгаж, аюулгүй ажиллагааны мэдлэг олгох	2 ажилтаныг ХАБЭА-н болон мэргэжил дээшлүүлэх сургалтанд хамруулж, үнэмлэх болон сертификат олгох	400.000
5	Нийт ажилчидын хоолны материал, чанарт анхаарах	Хоолны материал , амт чанарт анхааран шинэ хүнс ногоог худалдан авдаг. Мөн хүнс ногооны хадгалалтын тухай анхан шатны сургалтыг хийсэн болно.	100.000
			950.000

3.7.1 Говьсүмбэр аймгийн ОБГ-тай хамтран гал түймэр унтраах болон аврах тактикийн сургуулилт зохион байгуулав.



3.7.2 Говьсүмбэр аймгаас зохион байгуулж буй Гамшгийн эрсдэлээс сэргийлэх урьдчидсан арга хэмжээнд байгууллага тус бүрээс 1 хүн хамруулах байсан ба оосорлогч Пүрэвдорж хамрагдан амжилттай оролцсон.



3.7.3 Оосорлогч Бат-Очир, Пүрэвдорж нарыг оосорлогч, дохиочин болон аюулгүй ажиллагааны сургалтад хамруулан Пүрэвдоржид үнэмлэх олгов.



3.7.4 Хоолны амт чанарт анхааран мэргэжлийн тогооч хүний биед өдөрт авах илчлэгийн хэмжээг тооцон шинэ хүнс ногоогоор хоол хийдэг. Мөн цэвэр тав тухтай орчинд хооллодог.



-Тухайн жилийн менежментийн төлөвлөгөөний удирдлага зохион байгуулалтын биелэлтэнд 2023 онд 500.000 төгрөгийг зарцуулсан байна.

3.8 Орчины хяналт шинжилгээний хөтөлбөр

Д/д	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналт шинжилгээ хийх байршил	Хугацаа ба давтамж
1. Агаарын чанарын хяналт шинжилгээ			
1.	Агаарын бохирдлын шинжилгээ хийлгэх	Төсөл хэрэгжих талбайд хяналтын цэг сонгох /вагон эсткад ачиж буулгах талбайн ойр орчим/	Агаарын найрлага жилд 1 удаа
2.	Агаарын тоосны шинжилгээг мэргэжлийн байгууллагаг хийлгэх дуу, шуугиан, чичэргээ гэх мэт		Тоосны хяналт: Төслийн талбайд жилд 1 удаа
2. Усны хяналт шинжилгээ			
1.	Усны ерөнхий шинжилгээ: /рН, Хатуулаг, хлор, төмөр, нитритийн ион, аммонийн ион, кальци, магни, фтор Нян судлал: Гэдэсний савханцар, нян бактерийн ерөнхий тоо	Оффисын худаг болон агуулахын худагнаас	Ерөнхий үзүүлэлт, нян судлал жилд 1 удаа
3. Хөрсний хяналт шинжилгээ			
1.	Хөрсний хими, физик, шинж чанарыг тодорхойлох: Хүнд металл: Кадми, Хар тугалга, Мөнгөн ус, Хром, Стронци	Ачилт буулгалтын талбайн ойр орчмын газраас	Хөрсний хими, физик шинж чанарыг жилд 1 удаа
2.	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгагдсан агаар ус хөрсний шинжилгээг байгаль орчны итгэмжлэгдсэн лабораториар хийлгэж хүнд металлын агууламжийг тодорхойлуулах шинжилгээний дүнг үндэслэн МХГ-ын эрүүл ахуй, байгаль орчны хяналтын байцаагчаар дүгнэлт гаргуулах:	Төсөл хэрэгжих талбайд хяналтын цэг сонгох	Жилд 1 удаа
ДҮН			3.500.000

-“EACC” ХХК нь агаар, хөрс, усны шинжилгээг хариуцан жилд 2 удаа ирэн хийдэг.

Хөрсний, агаарын дээж авч буй байдал:



-Ус болон хөрсний дээж авч буй байдал





ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР
БАЙГАЛЬ ОРЧИН, ХЭМЖИЛ ЗҮЙН
ТӨВ ЛАБОРАТОРИ

17043, Үйлдвэр 2-4, Чингисийн өргөн чөлөө гудамж,
Хан-Уул дүүрэг, 20-р хороо, Утас: 11-341818
E-mail: bohzi@gmail.com

СОРИЛТЫН ДҮН



Дугаар он/№ : 2023/A-66
Дээжийг ирүүлсэн газрын нэр, хаяг, утас : "ЕАСС"ХХК
Дээжийг авсан хүний нэр, албан тушаал : Д.Сувд агаарын хэсэг
Дээжийн тоо, төрөл : 2 агаар, 2 дуу чимээ
Сорьц авсан огноо : 2023.04.11
Дээжийн тодорхойлолт : Говьсүмбэр аймаг сүмбэр баг 108-ойл ХХК
Гаалийн хяналтын талбай
Шинжилгээний аргын стандарт : MNS 17.2.5.12.88, MNS 17.2.5.11.88, DUSTRAK8530
Шинжилсэн огноо : 2023.04.18
Хуудасны тоо : 1/1
Үр дүн :

№	Сорьц авсан цаг	Сорьц авсан өдөр	Сорьц авсан цаг	Хүхэрлэг хий мг/м ³	Азотын давхар исэл мг/м ³	Нийт Тоос /TSP/ мг/м ³	Дуу чимээ /ДБА/
1	Ачилт буулгалтын талбай	IV/11	12:20	0.020	0.025	0.105	54
2	Гэр хороолол дундаас	IV/11	12:20	0.022	0.024	0.060	50
Агаарын чанарын стандарт MNS 4585:2016 (20 минутын хэмжилт)				0.450	0.200	0.500	60

Шинжилгээ гүйцэтгэсэн:
Агаарын хэсгийн инженер

Хянаж баталгаажуулсан:
Агаарын хэсгийн инженер



Э.Оюунтуяа

Д.Түмэндэлгэр

Хуулбарлан хэрэглэхийг хориглоно.
Сорилтын дүн нь зөвхөн шинжилсэн сорьцонд хүчинтэй



ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР
БАЙГАЛЬ ОРЧИН, ХЭМЖИЛ ЗҮЙН
ТӨВ ЛАБОРАТОРИ

17043, Үйлдвэр 2-4, Чингисийн өргөн чөлөө гудамж,
Хан-Уул дүүрэг, 20-р хороо, Утас: 11-341818
E-mail: bohztii@gmail.com



СОРИЛТЫН ДҮН

Дугаар он/№ : 2023/A-244
Сорьц ирүүлсэн газрын нэр, хаяг, утас : * ЕАСС *ХХК
Сорьцын авсан хүний нэр, албан тушаал : Д.Сувд агаарын хэсэг
Сорьцын тоо, төрөл : 2 агаар, 2 дуу чимээ
Сорьц авсан огноо : 2023.09.13
Сорьцын тодорхойлолт : Говьсүмбэр аймаг Сүмбэр сум
108-ойл ХХК гаалийн хяналтын талбай
Шинжилгээний аргын стандарт : MNS 17-2-5-12:2021, MNS 17-2-5-11:2021
MNS 5002:2000, САЗ А07-2016
Шинжилсэн огноо : 2023.09.15
Хуудасны тоо : 1/1
Үр дүн :

№	Сорьц авсан цэг	Сорьц авсан өдөр	Сорьц авсан цаг	Хүхэрлэг хий	Азотын давхар исэл		Дуу чимээ
					Нийт тоос /TSP/	мг/м ³	
1	N 46 23'02.23" E 108 21'16.63" Гаалийн хяналтын талбай хашаан дотор	IX/13	12:10	0.012	0.023	0.149	60
2	N 46 21'59.80" E 108 22'09.44" Гэр хороолол дунд худаг орчим	IX/13	12:50	0.011	0.021	0.029	44
Агаарын чанарын техникийн ерөнхий шаардлага MNS 4585:2016 Зөвшөөрөгдөх дээд хэмжээ (20 минутын хэмжилт)				0.450	0.200	0.500	60

Шинжилгээ гүйцэтгэсэн инженер:

Хянаж баталгаажуулсан:
Байгаль орчны шинжилгээний хэлтсийн дарга



Э.Оюунтуяа

Б.Бархасрагчаа

Хуулбарлан хэрэглэхийг хориглоно.
Сорилтын дүн нь зөвхөн шинжилсэн сорьцонд хүчинтэй



ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ
ГАЗАРЗҮЙ - ГЕОЭКОЛОГИЙН ХҮРЭЭЛЭН
УСНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ЛАБОРАТОРИ

Усны химийн шинжилгээний тодорхойлолт

Сорьц авсан: 2023 оны 04 сарын 18 өдөр
Шинжилгээ хийсэн: 2023 оны 04 сарын 21 өдөр
Сорьц авсан газрын нэр: Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум
"Зуун Найман Ойл" ХХК, гаалийн хяналтын бүсийн худаг

Сорьц шинжлүүлсэн байгууллага, хувь хүн: "БАСО" ХХК

Солбицол X= Гүн: м
Y= Ундарга: л/с

Уст цэгийн төрөл ба дугаар: Худаг

Тодорхойлсон нь:

Анион	1 дм ³ -д байгаа			Катион	1 дм ³ -д байгаа		
	мг	мг-экв	мг-экв%		мг	мг-экв	мг-экв%
Cl ⁻	222.6	6.27	34.1	Na ⁺ +K ⁺	157.0	6.82	37.2
SO ₄ ²⁻	230.0	4.79	26.1	Ca ²⁺	122.0	6.09	33.2
NO ₂ ⁻	0.0	0.00	0.0	Mg ²⁺	65.3	5.37	29.2
NO ₃ ⁻	25.0	0.40	2.2	NH ₄ ⁺	0.0	0.00	0.0
CO ₃ ²⁻	0.0	0.00	0.0	Fe ²⁺	0.0	0.00	0.0
HCO ₃ ⁻	420.9	6.90	37.6	Fe ³⁺	1.5	0.08	0.4
Дүн	898.5	18.36	100.0	Дүн	345.8	18.36	100.0

HCO₃⁻ ийн хагасыг хассан анион катионуудын
нийлбэр: 1033.8 мг/дм³

Анион катионуудын
нийлбэр: 1244.3 мг/дм³

Ерөнхий хатуулаг: 11.46 мг-экв/дм³

EC: 1684 μS/cm

pH: 7.63

TDS: 1010 ppm

Исэлдэх чанар: 2.56 мг/дм³

Физик шинж чанар

Тунгалаг: 28 см
Өнгө: сул шаргалдуу

Үнэр: 0 балл
Амт: ***

Тунадас: үгүй
Булингар: 4.99 NTU

HCO₃⁻38 Cl⁻34 SO₄²⁻26

Усны найрлагын томъёо: M₁₂

Na⁺+K⁺37 Ca²⁺33 Mg²⁺29

Дүгнэлт

Химийн бүрэлдэхүүнээрээ холимог ангийн, холимог бүлгийн, 2-р төрлийн, чанарын хувьд давсархаг, маш хатуу ус байна. Шинжилсэн химийн үндсэн үзүүлэлтүүдээс ийрт эрдэс, ерөнхий хатуулаг, кальци, магни, төмрийн нонууд нь "Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ MNS 0900:2018" стандартад заасан хэмжээнээс их байгаа тул хүний ундаанд тохиромжгүй. Хүний ундаанд хэрэглэх тохиолдолд цэвэршүүлж, цэнгэгжүүлж, зөөлрүүлж хэрэглэх шаардлагатай.

Жич: Энэхүү уст цэгээс сорьц авах үйл явцыг шинжлүүлсэн байгууллага, хувь хүн хариуцан гүйцэтгэсэн болно

Гүйцэтгэсэн: Химич, ЭШДЭ  /Т.Энхжаргал/
Шинжилгээ
Хянасан: Лабораторийн эрхлэгч:  /Д. Гэрэлт-Од/



ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ
ГАЗАРЗҮЙ - ГЕОЭКОЛОГИЙН ХҮРЭЭЛЭН
УСНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ЛАБОРАТОРИ

Усны химийн шинжилгээний тодорхойлолт

Сорьц авсан: 2023 оны 09 сарын 13 өдөр
Шинжилгээ хийсэн: 2023 оны 09 сарын 14 өдөр
Сорьц авсан газрын нэр: Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум,
"Зуун Найм Ойл" ХХК, гаалийн хяналтын бүсийн худаг

Сорьц шинжлүүлсэн байгууллага, хувь хүн: "БАСС" ХХК

Солбицол X=46.38530833 Гүн: м
Y=108.3556972 Ундарга: л/с
Уст цэгийн төрөл ба дугаар: худаг

Тодорхойлсон нь:

Анион	1 дм ³ -д байгаа			Катион	1 дм ³ -д байгаа		
	мг	мг-экв	мг-экв%		мг	мг-экв	мг-экв%
Cl ⁻	236.1	6.65	37.5	Na ⁺ +K ⁺	133.8	5.82	32.8
SO ₄ ²⁻	165.0	3.44	19.4	Ca ²⁺	128.3	6.40	36.1
NO ₂ ⁻	0.0	0.00	0.0	Mg ²⁺	66.8	5.49	31.0
NO ₃ ⁻	45.0	0.73	4.1	NH ₄ ⁺	0.1	0.01	0.0
CO ₃ ²⁻	0.0	0.00	0.0	Fe ²⁺	0.0	0.00	0.0
HCO ₃ ⁻	420.9	6.90	39.0	Fe ³⁺	0.0	0.00	0.0
Дүн	867.0	17.71	100.0	Дүн	328.9	17.71	100.0

HCO₃⁻ ийн хагасыг хассан анион катионуудын
нийлбэр: 985.4 мг/дм³ Анион катионуудын
нийлбэр: 1195.9 мг/дм³

Ерөнхий хатуулаг: 11.89 мг-экв/дм³ EC: 1625 µS/cm
pH: 7.96 TDS: 975 ppm

Исэлдэх чанар: 4.16 мг/дм³

Физик шинж чанар

Тунгалаг: 30 см Үнэр: 0 балл Тунадас: үгүй
Өнгө: үгүй Амт: *** Булинггар: 3.29 NTU

HCO₃⁻39 Cl⁻38 SO₄²⁻19

Усны найрлагын томъёо: M₁₂

Ca²⁺36 Na⁺+K⁺33 Mg²⁺31

Дүгнэлт

Химийн бүрэлдэхүүнээрээ гидрокарбонат-хлорын ангийн, халимог бүлгийн, 3-р төрлийн, чанарын хувьд давсархаг, маш хатуу ус байна. Шинжилсэн химийн үндсэн үзүүлэлтүүдээс нийт эрдэс, ерөнхий хатуулаг, магни, кальцийн ион нь "Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, ахуйгүй байдлын үнэлгээ MNS 0900:2018" стандартад заасан хэмжээнээс их байна.

Жич. Энэхүү уст цэгээс сорьц авах үйл явцыг шинжлүүлсэн байгууллага, хувь хүн хариуцан гүйцэтгэсэн болно

Гүйцэтгэсэн: Химич, ЭШДЭА _____ /Т. Энхжаргал/
Шинжилгээ
Хянасан: Лабораторийн эрхлэгч: _____ /Д. Гэрэлт-Од/



**ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ
ГАЗАРЗҮЙ ГЕОЭКОЛОГИЙН ХҮРЭЭЛЭН
ХӨРСНИЙ ЛАБОРАТОРИ**

Хаяг: Монгол улс, Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг,
7-р хороо, Эрхүүгийн гудамж, 11-р хороолол
Утас: +976 99141955
E-mail: soillab.IGG@gmail.com

Хөрсний задлан шинжилгээний дүн

Дээж авсан газрын нэр: Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, "Зуун найман ойл" ХХК,
гаалийн хяналтын бүсийн талбай

Дээж шинжлүүлсэн байгуулага: "ЕАСС" ХХК

Шинжилгээ хийсэн огноо: 2023 он 04 сар 14

Хөрсний химийн үндсэн шинж

№	Дээжний дугаар	Гүн, см	Солбицол	pH _{н.д} (1.5)	CaCO ₃ %	Ялзмаг %	ЕС1: 5 dS/m	Хөдөлгөөнт, мг/100г	
								P ₂ O ₅	K ₂ O
1	JS-1	0-20	46 383 108 354111	8.85	1.45	0.516	0.329	1.07	8.0
2	JS-2	0-20	46 384723 108 355723	8.12	0.55	0.704	0.318	2.61	19.4
3	JS-3	0-20	46 379806 108 355083	8.53	0.00	1.172	0.146	1.65	15.6

Хөрсний механик бүрэлдэхүүн

№	Дээжний дугаар	Гүн, см	Солбицол	Ширхэгийн хэмжээ, % (мм-ээр)		
				Элс (2-0.05мм)	Тоос (0.05-0.002мм)	Шавар (< 0.002мм)
1	JS-1	0-20	46 383 108 354111	70.2	19.0	10.8
2	JS-2	0-20	46 384723 108 355723	77.5	13.2	9.3
3	JS-3	0-20	46 379806 108 355083	73.1	17.4	9.5

Товч дүгнэлт:

Хөрс нь шүлтлэг урвалын орчинтой, JS-3 карбонатгүй, бусад дээж бага зэрэг карбонаттай, ялзмагийн агууламжаар бага зэрэг, цахилгаан дамжуулах чанараар бага буюу давсжилтгүй, хөдөлгөөнт фосфорын хангамжаар JS-2 дунд зэрэг, бусад дээж бага зэрэг, хөдөлгөөнт калийн хангамжаар бага зэрэг, механик бүрэлдэхүүн JS-2 элсэрхэг, бусад дээж элсэнцэр. Хөрсний үржил шимийн ерөнхий түвшин бага.

Шинжилгээний арга

pH, ЕС-MNS ISO 10390 2001- Ионметр, кондуктометр
CaCO₃-Кальциметр (10% HCl)
Ялзмаг-Тюрин (Walkley & Black)
Хөдөлгөөнт фосфор, кали-Спектрофотометр, Дөлөн фотометр-Мачигин (1% (NH₄)₂CO₃)
Хөрсний механик бүрэлдэхүүн-Гидрометрийн арга

Хөрсний лабораторийн эрхлэгч, доктор (Ph.D.)  Х.Золжаргал





**ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ
ГАЗАРЗҮЙ ГЕОЭКОЛОГИЙН ХҮРЭЭЛЭН
ХӨРСНИЙ ЛАБОРАТОРИ**

Хаяг: Монгол улс, Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг,
7-р хороо, Эрхүүгийн гудамж, 11-р хороолол

Утас: +976 99141955

E-mail: soillab.IGG@gmail.com

Хөрсний задлан шинжилгээний дүн

Дээж авсан газрын нэр:

Говьсүмбэр аймгийн Сүмбэр сум.

"Зуун найман айл" ХХК, Гаалийн хяналтын талбай

Дээж шинжлүүлсэн байгууллага, хувь хүн:

"ЕАСС" ХХК

Шинжилгээ хийсэн огноо:

2023 он 09 сар 15

Хөрсний химийн үндсэн шинж

№	Дээжний дугаар	Гүн, см	pH _{H2O} (1.5)	CaCO ₃ %	Ялзмаг %	EC _{2.5} dS/m	Хөдөлгөөнт, мг/100г	
							P ₂ O ₅	K ₂ O
1	GS-1	0-20	8.72	2.00	0.915	0.149	1.22	14.3
2	GS-2	0-20	8.75	1.45	0.289	0.091	0.56	9.5
3	GS-3	0-20	8.36	0.00	1.308	0.052	1.44	16.2

Хөрсний ширхэгийн бүрэлдэхүүн

№	Дээжний дугаар	Гүн, см	Ширхэгийн хэмжээ, % (мм-ээр)		
			Элс (2-0.05мм)	Тоос (0.05-0.002мм)	Шавар (< 0.002мм)
1	GS-1	0-20	68.7	19.0	12.2
2	GS-2	0-20	83.4	7.9	8.7
3	GS-3	0-20	77.5	11.7	10.8

Товч дүгнэлт:

Хөрсний урвалын орчноор бүх дээж шүлтлэг, ялзмагийн агууламжаар бүх дээж бага зэрэг, цахилгаан дамжуулах чанараар бага буюу давсжилтгүй, хөдөлгөөнт фосфор болон калийн хангамжаар бүх дээж бага зэрэг, ширхэгийн бүрэлдэхүүнээр GS-1 элсэнцэр, GS-2, GS-3 элсэрхэг. Хөрсний үржил шимийн ерөнхий түвшин бага.

Шинжилгээний арга

pH, EC-MNS ISO 10390:2001- Ионметр, кондуктометр

CaCO₃-Кальциметр (10% HCl)

Ялзмаг-Тюрин (Walkley & Black)

Хөдөлгөөнт фосфор, кали-Спектрофотометр, Дөлөн фотометр-Мачигин (1% (NH₄)₂CO₃)

Хөрсний ширхэгийн бүрэлдэхүүн-Гидрометрийн арга

Хөрсний лабораторийн эрхлэгч, доктор  Х Золжаргал

-Орчины шинжилгээний хөтөлбөрт 2023 онд нийт 3.500.000 төгрөгийг зарцуулсан байна.

Дүгнэлт

“ Зууннайман ойл “ ХХК-ийн Гаалийн хяналтын бүс нь Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын 1-р багийн нутаг дэвсгэрт 76000 т.кв талбайд хэрэгжих ГХБ төсөл нь 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг боловсрууллаа.

Төслийн хувьд байршил, үйл ажиллагааны улмаас экологи- байгаль орчин, хүн амын эрүүл ахуй, нийгэм эдийн засагт үзүүлэх гол нөлөөллийг байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний хүрээнд тодорхойлсныг 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд сөрөг нөлөөллийг бууруулах , арилгах талаар авч хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ажлуудыг шат дараалан хийн гүйцэтгэж сөрөг нөлөөллийг арилгах , бууруулах арга хэмжээг авч ажилласан.

2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ
ХҮЛЭЭЖ АВАХ, ДҮГНЭХ ХУУДАС

Огноо:

Дугаар:

Байршил:

Ажлын хэсгийн дарга:

_____ (аймаг, нийслэл)-ийн _____ (сум/дүүрэг)-ийн
Засаг дарга _____ (эсвэл томилогдсон албан тушаалтан)

Гишүүд:

Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын байгаль орчны хяналтын улсын
байцаагч(_____)

Байгаль орчны газрын төлөөлөл (_____)

Сав газрын захиргааны төлөөлөл (_____)

Сумын байгаль орчны хяналтын улсын байцаагч(_____)

Хариуцсан хэсгийн байгаль хамгаалагч(_____)

Нөлөөллийн бүс дэх иргэдийн төлөөлөл(_____)

Газрын даамал (_____)

Хүлээн зөвшөөрсөн:

“Зууннайман ойл” ХХК-ийн захирал (_____)